



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/235

Булган сум

### Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Улсын их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.1.3.1, 1.6.1.1, 1.6.1.6, 1.6.3.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөөгийн хүн амд чиглэсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг нэг дороос хурдан шуурхай, чанартай хүргэх зорилгоор "Хүрч үйлчилье" нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. "Хүрч үйлчилье" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: С.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын дарга)  
Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний  
газрын дарга)  
Ц.Энх-Амгалан (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)  
Б.Ариунболд (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн  
дарга)  
Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)  
Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл  
мэндийн хэлтсийн дарга)  
Б.Урангаваа (Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ,  
үнэлгээний хэлтсийн дарга)  
П.Оюунцэцэг (Нэгдсэн эмнэлгийн дарга)  
Б.Оюунгэрэл (Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн эмч)  
Б.Цогтгэрэл (Нэгдсэн эмнэлгийн ЭБЭ-ийн тасгийн эмч)  
Х.Олзмөнх (Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн эмч)

Б.Батболд (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Д.Батбаяр (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хүнс, тэжээлийн дэмжлэг туслалцаа хариуцсан мэргэжилтэн)

Б.Алтанбулаг (Мал эмнэлгийн газрын мал аж ахуйн хяналтын улсын байцаагч)

Ж.Хулангаа (Биеийн тамир спортын газрын арга зүйч)

Г.Нарантуяа (Биеийн тамир спортын газрын арга зүйч)

Д.Нямсүрэн (Улаан загалмайн хорооны арга зүйч)

Я.Нямсүрэн (Боловсрол, шинжлэх ухааны газрын Биеийн тамирын боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Солонго (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

3.Арга хэмжээг чанартай, хурдан шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга, Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасгай.

4.“Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 3,089,240 (гурван сая наян есөн мянга хоёр зуу дөч) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023. оны  
ОН дүгээр сарын 10...ны өдрийн А/235 дугаар  
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ "ХҮРЧҮЙЛЧИЛБЭ" НЭГДСЭН  
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1	2	3	4	5	6
1	Шатахууны зардал (5 машин 2150 км)	Литр	387	2520	975,240
2	Хэвлэлийн зардал (хулдаасан хэвлэл 2*3 м)	М <sup>2</sup>	3*3	12700	114,000
3	Хүнсний багц (гурил, будаа, тос)	Өрх	40	50000	2,000,000
	Дүн				3,089,240